

МАНАЙ ЛАВЛАХ

**1992 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ  
ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН  
ЖАГСААЛТ\***

(Эхний хагас жил)

1992.01.01. Дэлхийн Банкны Олон улсын хөгжлийн ассоциац (ОУХА)-аас Монголын эдийн засгийг сэргээн тогтворжуулах, техникийн туслалцаа үзүүлэх тухай гэрээнүүдэд Дэлхийн Банкны Зүүн Ази, Номхон далайн бүс орнуудыг хариуцсан дэд ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Шахид Бурки, БНМАУ-аас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Даваагив нар саяхан гарын үсэг зурав. Гэрээний дагуу Дэлхийн Банкны ОУХА манай улсад 35 сая долларын удаан хугацааны зээл олгох юм.

1992.01.07 Мягмар БНМАУ-ын Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн урилгаар манай оронд ажлын айлчлал хийсэн ЗСБН Буриад улсын СнЗ-ийн дарга В. Б. Саганов, БНМАУ-ын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн нар БНМАУ-ын Засгийн газар, ЗСБН Буриад улсын Засгийн газрын хооронд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын талаар хамтарч ажиллах тухай хэлэлцээрт гарын үсэг зурав.

1992.01.21 Мягмар БНМАУ, Украин улстай дипломат харилцаа тогтоов.

1992.01.22 Лхагва БНМАУ, БН Казахстан улс хоёр дипломат харилцаа тогтоов.

1992.01.24 Баасан БНМАУ, БН Беларусь улсын хооронд дипломат харилцаа тогтоож, мөн хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав.

1992.01.25 Бямба БНМАУ, БН Узбекистан улстай дипломат харилцаа тогтоов.

1992.02.19-24 Лхагва-Даваа Монгол улсын Дэд ерөнхийлөгч, Улсын Бага хурлын дарга Р.Гончигдорж БНСУ, Балба, Пакистан улсуудад айлчлав. Р.Гончигдоржийг Исламабадад байх хугацаанд Пакистаны Ерөнхийлөгч Гулам Исхак Хан болон парламентын хоёр танхимын дарга нар хүлээн авч уулзаж, хоёр орны парламент, Засгийн газар, шүүх засаглалын тогтолцооны асуудлаар санал солилцов.

1992.02.25-26. Мягмар-Лхагва Монгол улсын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн ХБНГУ-д айлчилж, Канцлер Г. Коль, Бундестагийн Дэд ерөнхийлөгч Д. Ю. Кроненберг нартай уулзаж, Монгол, Германы улс төр, эдийн засгийн харилцаа, түүний дотор парламентын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Мөн Германы үйлдвэр худалдааны төв танхимд зочилж, Германы санхүү, худалдаа, үйлдвэрийн хүрээ, зарим улс төрийн сан, байгууллагын төлөөлөгчидтэй уулзав.

\* «Ардын эрх» сониноос авав.

1992. 02. 26. Лхагва Хандивлагч орон, олон улсын байгууллагын төлөөлөгчдийн ажлын уулзалт Улаанбаатар хотод болж, Монгол улсын өнөөгийн байдал, 1992 оны үндсэн зорилт, хандивлагч орон, олон улсын байгууллагаас үзүүлж байгаа зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилтийн байдлыг хэлэлцлээ.

1992.02.27 Пүрэв Монгол улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн Францад ажлын айлчлал хийх үеэр Францын Ерөнхийлөгч Франсуа Миттеран ашигтай болзлын үндсэн дээр Монголд зээл олгохыг зарчмын хувьд зөвшөөрөв. Айлчлалын явцад хоёр орны эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны асуудал хэлэлцлээ.

1992.03.02-03. Даваа-Мягмар Монгол улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн Бельги, ЕЭЗХН-т айлчилж, Бельгийн Ерөнхий сайд В. Мартенс, Гадаад худалдааны яамны сайд Р. Юрбэн нартай уулзан, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов. Айлчлалын үеэр Монгол-Бельги-Люксембургийн эдийн засгийн холбооны хооронд хөрөнгө оруулалтыг харилцан дэмжиж, хамгаалах тухай хэлэлцээр байгуулав.

1992.03.03 Мягмар Монгол улс, БН Армен Улстай дипломат харилцаа тогтоов.

1992.03.05 Пүрэв Монгол улсын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн Оросын Холбооны Улсад ажлын айлчлал хийх үеэр Оросын Засгийн газрын дэд сайд Александр Шохинтай Москвад хэлэлцээ хийв. Тус хэлэлцээний үеэр хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааны асуудалд гол анхаарлаа хандууллаа. Тухайлбал, Оросоос эрчим хүчний эх булаг нийлүүлэх тухай манай улсын хувьд маш чухал асуудал шийдвэрлэв.

1992.03.05 Пүрэв Монгол улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн, БН Хальмаг-Тангч улсын СнЗ-ийн дарга Б. Михайлов нар хоёр улсын Засгийн газраас соёл боловсрол, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах, эдийн засаг, барилгын салбарт 1992—1995 онд хамтран ажиллах хөтөлбөрт Москва хотноо гарын үсэг зурав.

1992.03.20 Баасан Монгол-Италийн хооронд 1992—1994 онд соёлын салбарт хамтран ажиллах төлөвлөгөөг тус улсаас Итали улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Л.Хашбат, Италийн ГЯЯ-ны соёлын харилцааны ерөнхий захирал Ватани нар Ром хотноо үзэглэв.

1992.03.24 Мягмар Монгол улсын Засгийн газрын шадар сайд Д.Дорлигжав Засгийн газрын урилгаар манай оронд айлчилсан Олон улсын атомын энергийн агентлагийн Ерөнхий захирлын орлогч, техникийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга ноён Норабли Бин Муслимыг хүлээн авч уулзав. Уулзалт ярианы үеэр Монгол Улсын Засгийн газрын цөмийн энергийн комисс, Олон улсын атомын энергийн агентлагийн техникийн хамтын ажиллагааны явц үр, дүн, хэтийн төлөвийн талаар санал бодлоо солилцов. Тус агентлагаас зөвлөснөөр манай улс Ази, Номхон далайн бүсийн хамтын ажиллагааны гэрээнд нэгдэж орохоор шийдвэрлэв.

1992. 03. 28–30. Бямба-Даваа Япон улсад айлчилсан Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн Монгол, Японы хамтын ажиллагааг өргөжүүлэх, Япон улсаас Монголд тусламж дэмжлэг үзүүлэх, Японы Засгийн газрын удирдлагад Монголын өөрчлөлт шинжлэлтийн явцыг танилцуулах, хоёр орны харилцааг хөгжүүлэх талаар санал бодлоо солилцов.

Бямба тогтоохоор шийдвэрлэв.

1992.04.04 Монгол улс, Ватикан улстай дипломат харилцаа

1992.04.13 Давааа Монгол улсын АИХ-ын дарга Ж. Уртнасан БНАСАУ-ын төр, засгийн урилгаар БНАСАУ-д айлчилж, Ерөнхийлөгч Ким Ир Сений 80 насны ойн баяр ёслолд оролцож Ерөнхийлөгч П.Очирбатын илгээлтийг гардуулав.

1992.04.16 Пүрэв Монгол улс Азербайжан улстай дипломат харилцаа тогтоов.

1992.04.17-20. Баасан-Даваа Монгол улсын Дэд ерөнхийлөгч, Улсын Бага хурлын дарга Р.Гончигдоржийн урилгаар БНЭУ-ын Дэд ерөнхийлөгч, доктор Ш.Д. Шарма, Монгол улсын Засгийн газрын урилгаар БНСУ-ын ГЯЯ-ны сайд Ли Сан Ок нар манай оронд албан ёсны айлчлал хийв, Айлчлалын үеэр Монгол улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газрын хооронд эдийн засаг, техникийн салбарт хамтран ажиллах тухай; Монгол улс, БНСУ-ын хооронд «Орлогын татварыг давхар ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийхийг сэргийлэх тухай хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав.

1992.04.20 Даваа Монгол улсын Бага хурлын дарга Р.Гончигдорж тэргүүтэй парламентын төлөөлөгчид АНУ-ын Гавайн аралд болсон Ази, Номхон далайн орнуудын парламентын удирдагчдын зөвлөгөөнд оролцов.

1992.04.22 Лхагва Монгол улс, Кыргызстан улстай дипломат харилцаа тогтоов.

1992.04.23 Пүрэв Монгол улс, БНТуркменистан улстай дипломат харилцаа тогтоов.

Монгол улсын Бага Хурлын орлогч дарга, Монгол, Оросын парламентын бүлгийн дарга К. Зарды хан, Улсын Бага хурлын урилгаар манай оронд албан ёсны айлчлал хийсэн Орос Улсын Дээд Зөвлөлийн Үндэсний зөвлөлийн дарга Р.Г. Абдулатипов нар Монгол Улс, Орос улсын парламент хоорондын хэлхээ холбоог хөгжүүлэх тухай тохиролцооны протоколд гарын үсэг зурав.

1992.04.24 Баасан Энэ оны 5-р сарын сүүлчээр Токио хотноо болох Монголыг дэмжигч, хандивлагч орнуудын уулзалтанд бэлтгэх асуудлын хүрээнд ажлын уулзалт хийж, санал солилцохоор Японы Засгийн газрын шинжилгээний төлөөлөгчид Улаанбаатар хотноо хүрэлцэн ирэв.

1992.04.24-27 Баасан-Лхагва Монгол Улсын Засгийн газрын урилгаар ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал, ноён Федерико Майор манай оронд албан ёсоор айлчлал хийх хугацаандаа Монголын үндэсний комиссын дарга, Га-

даад харилцааны дэд сайд Х. Бэхбаттай хэлэлцээ хийж, Монгол улс, ЮНЕСКО-гийн хооронд байгуулсан «Санамж бичиг»-т гарын үсэг зурав.

1992.05.01-04 Баасан-Даваа Японы парламентын зөвлөхүүдийн танхимын дарга ноён Южи Осада тэргүүтэй төлөөлөгчид Улсын Бага хурлын урилгаар манай оронд албан ёсны айлчлал хийв.

1992.05.07 Пүрэв Монгол улсын Засгийн газрын шадар сайд Ч.Пүрэвдорж Цөмийн энергийн комиссын шугамаар ирсэн Олон улсын атомын энергийн агентлагийн бие төлөөлөгч, доктор Рияд С. Камел тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан тус агентлаг манай улс хоорондын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв, техникийн туслалцаа болон бусад асуудлаар санал солилцов.

1992.05.07-11 Пүрэв-Даваа БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэний урилгаар Монгол улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн БНХАУ-д албан ёсны найрсаг айлчлал хийх хугацаанд Монгол, Хятадын хамтын ажиллагааг өргөтгөхөд чиглэсэн 4 баримт бичиг (хоёр улсын Засгийн газар хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, Хятадын Засгийн газраас Монголын Засгийн газарт зээл олгох тухай хэлэлцээр, Хоёр улсын хоорондын ургамлын хорио цээрийн тухай хэлэлцээр, хоёр орны хооронд байгуулсан авто тээврийн хэлэлцээрийн хүрээнд авто машинаар ачаа, зорчигч тээвэрлэх баримт бичиг)-т 5-р сарын 9-нд Бээжин хотноо гарын үсэг зурах ёслолд оролцов.

1992.05.12 Мягмар Монгол улс, БН Гүрж улстай дипломат харилцаа тогтоов.

1992.05.18 Даваа Монгол улс, Бруней Даруссалам Улстай дипломат харилцаа тогтоов.

1992.05.20 Лхагва БН Саха (Якут) улсын Гадаад харилцааны яамны 1-р орлогч сайд Ю.Н. Буслаев тэргүүтэй төлөөлөгчид манай оронд айлчилж, хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар холбогдох яам, байгууллагын удирдлагатай уулзаж санал солилцов.

1992.05.14-15 Пүрэв-Баасан Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн Индонез улсад болсон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний ГЯЯ-дын сайд нарын хуралд оролцож, Бруней улсад айлчлав.

1992.05.22 Баасан Монгол, Украины Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай болон төлбөрийн тухай хэлэлцээрт Киев хотноо гарын үсэг зурав.

1992.05.28-29 Пүрэв-Баасан Монгол улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн Япон улсын Засгийн газрын урилгаар Япон улсад ажлын айлчлал хийх хугацаандаа Монголыг дэмжигч орнуудын Токиогийн 11 уулзалтанд оролцож, Япон улсын Ерөнхий сайд К. Миязава болон албаны бусад хүн, эдийн засгийн байгууллагуудын удирдлагатай уулзав.

1992.06.01 Даваа Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн, Украин улсын ГЯЯ-ны сайд А. М. Зленко нар Киев хотноо албан ёсны хэлэлцээ хийж, хоёр

талын болон олон улсын хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал бодлоо солилцов. Монгол улс, Украин улсын хоорондын хамтын ажиллагааны тухай гэрээг хоёр тал тохиролцон үзэглэж, Монгол, Украины хооронд консулын харилцаа тогтоох тухай протоколд гарын үсэг зурав,

1992.06.02 Мягмар Худалдаа, эдийн засаг, Шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны төгсгөлд Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засгийн төлөөлөгчид хэлэлцээр хийж, комиссын анхдугаар хуралдааны протокол, 1992 онд худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллах протокол, төлбөрийн хэлэлцээр гэсэн 3 үндсэн баримт бичигт Улаанбаатар хотноо гарын үсэг зурлаа.

1992.06.09 Мягмар Монгол улс, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны зөвлөлдөх комиссын Монголын хэсгийн урилгаар айлчилсан зөвлөлдөх комиссын БНАСАУ-ын хэсгийн дарга, БНАСАУ-ын Орон нутгийн үйлдвэрийн яамны сайд Ким Сон Гу тэргүүтэй төлөөлөгчид Монгол улсын Ерөнхийлөгч П.Очирбатад бараалхаж, хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны талаар ярилцав.

Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн БН Австри улсын Засгийн газрын урилгаар албан ёсны айлчлал хийх хугацаандаа Австрийн ГЯЯ-ны сайд Мокктай Монгол, Австрийн соёлын харилцааны тухай хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурж, хоёр талын эдийн засгийн гадаад харилцааны тухай хэлэлцээрийг үзэглэв.

1992.06.17 Лхагва Монгол улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн Бразили улсын Риоде-Жанейро хотноо болсон Байгаль орчин, хөгжлийн асуудлаарх дэлхий дахины бага хуралд оролцоод буцах замдаа Люксембургт ЕЭЗХН, Монгол улсын хооронд хэлэлцээр байгуулав. Монгол улсын эрчим хүч, холбооны салбарыг хөгжүүлэхэд Япон улсаас буцалтгүй тусламж үзүүлэх тухай хоёр дахь ноотод Худалдаа, үйлдвэрийн сайд С. Баярбаатар, Япон улсаас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, ноён Шожи Суэзава нар гарын үсэг зурав.